Академич Б.Рагчаагийн элэг судлалын бүтээлийн үнэ цэнэ

Д.Долгион[1], А.Энх-Амар[1], С.Бадамжав[1]

[1]АШУҮИС. ХБЭС-ийн тэнхим

“Алт хэдий удсан ч өнгө нь хувирахгүй Алдартан хэдий өнгөрсөн ч нэр нь мартагдахгүй.”

Анагаахын шинжлэх ухааны түүхэн судалгааны явцыг ажиглаж үзэхэд намтар, түүхийн чиглэлээр хийсэн судалгааны ажил нь цөөхөн байсан ба энэ чиглэлийн судалгааны ажлыг тухайн салбараас төрөн гарсан үе үеийн эрдэмтэн нарын намтар бүтээлээр баримтжуулж, тэдний алдар гавьяа түүхэн замнал, анагаахын шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийг тодорхойлох нь нэн чухал асуудал болон тавигдаж байна[1].

XX зуунд Монголын анагаах ухааны салбаруудын дотроос эмнэл зүйн анагаах ухаан илүү хөгжсөн түүхтэй. Эмнэл зүйн анагаах ухааны хаан хэмээн зүй ёсоор нэрлэгддэг дотрын анагаах ухааныг Монгол Улсад үүсгэн хөгжүүлэхэд МУИС-ийн хүн эмнэлгийн факультетийн анхны төгсөгчдийн нэг, анхны дотрын эмч, багш, дотрын эмгэг судлалын анхны аспирант, эрдэмтэн, анхны монгол декан, дотрын тэнхимийн анхны монгол эрхлэгч, анхны профессор, Монгол улсын хүний гавъяат эмч, Монгол улсын ШУА-ийн анхны сурвалжлагч гишүүн, анагаахын шинжлэх ухааны доктор, академич Б.Рагчаа жинтэй хувь нэмэр оруулсан билээ. Цаг тооны үргэлжлэлд өнгө нь үл хувирах шижир алт лугаа адил мөнхөд дуурсагдах хүмүүний нэг бол Боржигон овогт академич Бямбажавын Рагчаа багш юм.[2]

Хувьсгалын өмнөх монголд ардын эмнэлэг хөгжиж байсан боловч орчин үеийн анагаах ухаан, эмчлэн сэргийлэх систем тогтож чадаагүй байв. Эмнэлэг эмнэлгийн үйлчилгээ байгаагүйгээс хүн амын нас баралт 1000 хүн тутамд 25-30 хувьд хүрч, хүний дундаж наслалт 45-аас дээш гарахгүй байжээ. Энэ байдлыг гадаадын зарим жуулчид монголчуудыг мөхөж байгаа үндэстэн гэж тооцоход хүрч байлаа.[3]

Монгол улсын их сургууль 1942 оны 10 сарын 5-нд байгуулагдаж түүний харъяанд хүн эмнэлгийн факультет 34 оюутантай (24 монгол, 10 орос), 7 тэнхимтэйгээр хичээлээ эхэлсэн нь үндэсний дээд боловсролтой их эмч бэлтгэх боломж бүрджээ. МУИС-ын захирлын 1944 оны 8 сарын 29-ний өдрийн 36 тоот тушаалаар А.А.Дубинскийг Дотрын өвчнийг шинжлэн судлах тэнхимийн эрхлэгчээр томилсон нь дотрын тэнхимийн суурь тавигдсан түүхтэй. Б.Рагчаа 1947 онд дотрын тэнхимийн анхны аспирант болж, 1954 онд дотор өвчнийг шинжлэн судлах тэнхимийн эрхлэгчээр анх удаа монгол эрдэмтэн Б.Рагчаа томилогджээ.

Монгол Улсын Төв Номын сангийн 2005 оны архивын мэдээллийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа Б.Рагчаа багшийн эрдмийн ажлын бүтээлийн тухай нэгтгэн дүгнэсэн дүгнэлтийг олж харахад багшлах хугацаандаа 4000 орчим эмч мэргэжилтэн төгсгөн гаргаж, нийт 156 бүтээл туурвижээ.[4]

Рагчаа багш олон өвчнийг Монголд анх удаа оношлож судалж эмнэлгүүдийн архив, ном, сэтгүүлд нийтлүүлсэн нэрт эрдэмтэн хүн юм. Аль нэг өвчнийг анх ажиглан, эрдэм судалгааны эргэлтэд оруулан бичсэн хүний нэрээр тухайн өвчнийг нэрлэх явдал анагаах ухаанд элбэг агаад шинжлэх ухааны аливаа салбарт судалгаа, шинжилгээнийх нь үр дүн, хэрэглэгдэхүүнийг тухайн эрдэмтний нэр алдараар мөнхөлдөг нь тогтсон жишиг. Хэрэв манайд ийм зуршилыг мөрддөгсөн бол түүний нэр судалгааны ном, сурах бичгүүдэд нэн олон дурсагдан бичигдэх байсан бизээ. Тийнхүү Б.Рагчаа багшийн Монголд анх удаа оношлон судалсан өвчний нэг бол порфири өвчин байсан бөгөөд 1976 онд “Анагаах ухаан” сэтгүүлд энэ тухай судлагааны өгүүлэл нийтлүүлсэн байдаг. Мөн нэг жишээ нь онош тодорхойгүй өвчнөөр он удаан жил шаналж, элэгний хатуурал, зүрхний дутагдал,чихрийн шижин зэрэг олон таамаг оношийн дагуу эмчлүүлэн явсан нэгэн өвчтөнийг Б.Рагчаа багш бие махбодийн төмрийн солилцоо доголдсоноос үүсэх гемохроматоз өвчин хэмээн оношлосон нь мөн л Монголд оношлогдсон анхны тохиолдол байсан бөгөөд тэрхүү зөв оношлогооны дагуу цус авах эмчилгээг шинж тэмдгийн бусад эмчилгээтэй хавсарган хийснээр өвчтөн илааршиж байжээ.[5]

Дотрын өвчнийг европын болон уламжлалт аргаар хослон эмчлэх мэдлэг, авьяастайн дээр манай орны рашаан, шавар эмийн ургамлын онцлогийн сайн мэддэг байсан төдийгүй эмчилгээнд цурлах, ороох боох, хөлсөөр туух зэрэг аргыг дадамгай хэрэглэж олон хүнийг эмчилсэн маарамба манал бурханы шавь байлаа.3 “Элэгний архаг өвчнийг үхрийн нүдний шингэнээр эмчилсэн дүн”, “Хятад байцааны шүүс элэгний цочмог үрэвслийн үед хэрэглэсэн дүн”, элэгний архаг өвчнийг ямааны сүү, гүүний саамаар сувилан идэвхжихээс хамгаалах, элэгний архаг өвчинд Шаргалжуутын рашааны нөлөөлөл, хомоол, шатаасан жоншны ус уулгах, жамьянмядаг болон сэржмядаг цэцгийн ханд уух зэргийг судлан сонирхож үр дүнд хүрч байжээ. Уушиг, элэг зэрэг цул эрхтний хавдраас сэргийлэхэд “эрэнцэнтошил” гэдэг эм тустай болохыг бас ажиглан бичжээ.[6]

Халдварт хепатит манай оронд 1950 оноос тасралтгүй өссөөр 1957-1962 онд эрс нэмэгдэн

Улаанбаатар хотын 10000 хүнд 1961 онд 616 тохиолдол, 1962 онд 319,5 тохиолдол бүртгэснийг Т.Гомбосүрэн 1967 онд бүтээлдээ бичсэн байна. 1953-1961 он хүртэл Б.Рагчаа нь Элэгний үрэвслийн шалтгаант цочмог ба архаг гепатитийн тархалт, шалтгаан, эмнэл зүй, эмчилгээ, сэргийлэлтийн асуудлаар өргөн хүрээний судалгааг удирдан явуулж байжээ. Улмаар элэгний өвчний талаар бичсэн бүтээлүүдээ нэгтгэж дүгнэн 1977 онд "Боткины өвчний эмнэл зүй" гэдэг нэг сэдэвт зохиол бичиж анагаахын шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэргийг хамгаалжээ.[7]

Академич Б.Рагчаа 1960 онд Х.Чойбалсангийн нэрэмжит МУИС-ийн "Эрдэм шинжилгээний бичиг"-ийн V ботийн №2-т нийтлүүлсэн "Боткины өвчний зарим нэгэн шинж тэмдэг ба тархалтын байдлыг төв больницын 1956 оны баримтаар гаргаж судалсан нь" гэдэг сонирхолтой өгүүлэлдээ Боткины өвчний эзлэх хувийн жин 1956 онд 1948 оныхоос 5 дахин өөсөн, 1956 онд өвчлөгсдийн 73,2% нь өвчнийг тарилгийн замаар авсан гэсэн дүгнэлт хийснээрээ, Вирүст гепатитийн өвчлөл БНМАУ-д эрс нэмэгдэж эхэлсэн он цагийг тодруулснаараа, Алаг цоог өвчлөлийн дотор ийлдэст гепатит давамгайлж байсныг нотолснооров Монгол Улсад В вирүст гепатитийн судалгааны эхийг тавьсан ажээ.[8] (Академич П.Нямдаваа, 2009 он) . Өвчлөгсдийн 73,8% тарилгын болон цусаар дамждаг халдвартайг холбоотойг 1969 онд тэмдэглэснээс хойш 4 жилийн дараа , Австралийн эрдэмтэн В.С.Бланберг тарилгаар халддаг В вирүсийг илрүүлсэн.

Элгэнд хатгалт хийж эдийн сорьц авах эмгэг гистологийн шинжилгээ нь элэгний эмгэгүүдийг ялган оношлох, өвчний явцыг болон эмчилгээний хүндрэл, үр дүнг хянах шинжилгээ юм. 1883 онд Paul Ehrlich нарийн зүүгээр элэгний цуллаг эд рүү хатгалт хийж чихрийн шижинтэй өвчтөнүүдийн элгэнд гликогены нөөцийг тодорхойлсноор анагаах ухааны практикт анх нэвтрүүлжээ. 1923 онд Германд Bingel анхны элэгний амьд сорьцын шинжилгээний оношлогооны үр дүнг мэдээлсэн. 1958 онд Menghini "Нэг секундын элэгний хатгалтын эд сорьц" хэмээх техник болон Menghin-ий зүүг танилцуулсан ба түүнээс хойш арга технологи сайжирсаар ирсэн нь сүүлийн 50 гаруй жилд элэгний өвчний оношилгооны нотолгоот арга нь болоод байна. Академич Б.Рагчаа "Элэгний биопсийн ач холбогдол, үд дүн" сэдвээр Сэлэнгэ аймгийн эмч нарын комференцэд илтгэл (1966 он) хэлэлцүүлсэн нь энэ сэдвээр тавигдсан анхных нь байжээ. Хойд үеийн шавь нараас нь профессор Б.Дагвадорж, академич Б.Цэрэндаш, профессор Р.Сандуйжав нар биопсийн шинжилгээ хийж байсан нь уг оношлогоонд ач холбогдол өгч байгаагийн илрэл юм.

ШУГТЭ-ийн ХБЭС-ийн тасгийн эрхлэгч доктор, дэд профессор Д.Бадамсүрэн (2013он), УНТЭ-ийн ХБЭС-ийн төвийн эмч доктор Энхжаргал (2014он) нар элэгний биопсийн шинжилгээг улсын эмнэлгүүд дээр гардан хийснээр энэхүү оношлогоонд эргэлт гаргасан билээ. 2015 оны 6-р сарын 9-ны өдөр элэгний "Тэгшхүсэл" үүдэн эмнэлгийн амбулаторт доктор Д.Бадамсүрэн нэг өвчтөнд элэгний биопсийн шинжилгээг гардан хийж гавъяат эмч, профессор С.Бадамжав болон докторант Ц.Сарнай нар тусалж амжилттай хийгдсэн байна. Үүнээс хойш АШУҮИС-ийн их сургууль, Баянгол дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд анх хийснээс хойш эдүгээ 145 хүнд элэгний биопсийн шинжилгээ хийж, оношийг нь бататгасан байна.[9]

Академич Б.Рагчаагийн элэг судлалын бүтээлүүдээс дараах үр дүн харагдаж байна.[10]

1. Элэгний биопсийн шинжилгээний ач холбогдол, үр дүнгийн талаар тэртээ 1966 онд илтгэл хэлэлцүүлж энэ чиглэлийн суурийг анх тавьсан байна.
2. Монгол оронд тархсан халдварт гепатитын онцлогийг гарган дараачийн үеийнхэн цэгцтэй судлах боломж бүрджээ.
3. Халдварт хепатитийн үүсгэгч нь тогтоогүй байхад олон вирүс байж магадгүй болохыг харгалзан үзээд поливирүсийн хепатит гэж нэрлэх саналыг дэвшүүлсэн нь өнөө үед батлагджээ.
4. Үүсгэгч нь "А","В" 2 төрлийн вирүс байна гэдгийг тэмдэглэсэн. Үүнээс үндэслэн ийлдсийн хепатит нэршил, эмнэлзүйн онцлогийг гаргасан нь эмч, судлаачдад ач холбогдлоо өгсөн.

Ном зүй:

1. *Д.Алтантуул "Академич Б.Рагчаагийн дотор өвчний онош зүйн бүтээлийн судалгаа" 2016 он: 8*
2. *Б.Цэрэндаш "Монгол улсын шинжлэх ухаан" 2009 он: 6*
3. *Ж.Заанхүү, Т.Алтанцэцэг "Монголын түүхийн лекцүүд" 2008 он: 399-402*
4. *Монгол улсын төв номын сан, архивын фонд 2015 он*
5. *Б.Дагданбазар "Монголын анагаахын мэргэд" V боть :88*
6. *С.Бадамжав "Б.Рагчаа 100 жил" 2016 он: 145-146*
7. *С.Бадамжав "Монголд элэг судлалыг үндэслэгч эрдэмтэн" 2015 он: 36*
8. *П.Нямдаваа "Вакцин хэмээх ээлтэй Үхэржин" 2009 он*
9. *С.Бадамжав "Элэгний биопсийн шинжилгээ" 2019 он:15*
10. *Б.Рагчаа "Боткины өвчний эмнэл зүй" 1971 он*
11. *С.Бадамжав "Элэгний үрэвслийн шугаман эмчилгээ" 2017 он*
12. *С.Бадамжав "Элэг судлаач академич" 2016 он*
13. *Б.Рагчаа ""Дотор өвчний онош зүй" 1970 он*
14. *Б.Рагчаа "Дотор өвчний хам шинж" 1972 он*
15. *Б.Рагчаа "Туурвиж хэвлүүлсэн бүтээлүүдийн нийлбэрийн хураангуй" 1978 он*
16. *Б.Рагчаа "Монголын ард түмэнд анхааруулан зөвлөх нь" 1996 он (өөрийн гар бичмэл)*
17. *Т.Гомбосүрэн "Халдварт гепатитын эпидемиологи, урьдчилан сэргийлэх зарим асуудал" 1969 он*
18. *"Монгол улсын шинжлэх ухааны академийн гишүүд" 2011он:43-44*
19. *Ц.Түвшинжаргал, А.Гүрбадам "Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн процессорууд" анхдугаар хэвлэл 2017 он, 23-28х*
20. *А.Гүрбадам, Б.Дагданбазар, Ц.Түвшинжаргал Д.Нямдорж "Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн деканууд" 2019он:36-37*
21. *ЭМШУИС-ийн архивын материал (1984-2005 он)*
22. *П.Нямдаваа, Л.Лхагва " XX зууны Монголд анагаах ухаан хөгжсөн түүхийн товцоон" 2001 он*
23. *Г.Энхдолгор "Дотрын тэнхим нэгэн жаранд" 2005 он*